

БАТЛАВ.

“НИК” ХХК-ийн  
ГОВЬСҮМБЭР НХС-ЫН ДАРГА  
ДАРГА

Б.АНХБАЯР

БАТЛАВ.

“ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БОЛОВСРОЛ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР”-ИЙН  
ДАРГА

А.ЗУРГААНЖИН

## ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ЗЭЭЛЭЭР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 01-р сарын 02-ны өдөр

№. 2024 /3 / А-21.

Говьсүмбэр аймаг

Энэхүү гэрээг нэг талаас “НИК” ХХК /РД:2075261, УБД:9011250037/ төлөөлж Ахлах нягтлан бодогч Г.Ганбаяр (цаашид “Худалдагч” гэх), нөгөө талаас “ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР” /РД:9020314, УБД:000229461/-г төлөөлж эрхийн дагуу Нягтлан бодогч ажилтай Н.Одонтуяа (цаашид “Худалдан авагч” гэх) бид (цаашид дангаар нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) Иргэний хуулийн 243-264 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон, энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г дор дурдсан нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Худалдагч гэрээнд заасан нөхцөлийн дагуу МУ-ын чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүн /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ийг шатахууны карт ашиглан Худалдан авагчид дараа төлбөрт нөхцөлөөр нийлүүлэх, Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, бүтээгдэхүүний төлбөр, гэрээнд заасан хүүг төлөх, төлбөр төлөх хугацаа хожимдуулснаас тооцох алдангийн хэмжээ болон зээлээр бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдсон бусад бүхий л харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү гэрээ нь хүсэл зоригоо бүрэн илэрхийлж, сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд талууд гэрээний зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн уншиж танилцан, гарын үсэг зурж хүлээн зөвшөөрсөн болно.
- 1.3. Энэ гэрээний хавсралт, гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд энэхүү гэрээний хамт хүчин төгөлдөр байна.
- 1.4. Энэхүү гэрээг 2024 оны 01-р сарын 02-ны өдрөөс эхлэн 2024 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Худалдагч нь гэрээ байгуулсан тухайн сараас эхлэн бүтээгдэхүүнийг Худалдагчид дараа төлбөрт нөхцөлөөр, шатахууны картаар дамжуулан нийлүүлэх ба Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг УБ хотын ШТС-аас өөрийн тээврийн хэрэгслээр авах бөгөөд бүтээгдэхүүний үнэ тухайн ШТС дахь жижиглэнгийн үнэ байна. Энэхүү үнэнд НӨАТ орсон болно.



- 2.2. Худалдагчаас нийлүүлж буй бүтээгдэхүүний зээлийн шугам буюу Худалдагчийн авлагатай байх дээд хэмжээ **300,000 (гурван зуун мянга) төгрөг** байх бөгөөд Худалдан авагч энэхүү хэмжээнд багтаан худалдан авна.
- 2.3. Нийлүүлсэн шатахууны тоо хэмжээ нь түгээгүүрийн мэдээлэлд зааснаар тодорхойлогдоно.
- 2.4. Гэрээний 2.6-т заасан болон гэрээний бусад зүйлээр хоёр тал харилцан тохиролцон өөрчлөлт оруулах тохиолдолд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээтэй адил журмаар баталгаажуулна.
- 2.5. Худалдан авагч бүтээгдэхүүн хүлээн авсан тухайн сарын сүүлийн ажлын өдөр тооцоо нийлж, тухайн сардаа багтаан төлбөрийг бүрэн төлж барагдуулна.
- 2.6. Энэхүү гэрээний 2.5 дах хэсэгт заасан хугацаанд бүтээгдэхүүний төлбөрт тооцох хүү 0 хувь байна.
- 2.7. Бүтээгдэхүүний төлбөрийг зөвхөн төгрөгөөр тооцох бөгөөд төлбөрийг бэлэн бусаар буюу Худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 2.8. Худалдан авагч тал нь шатахууны худалдан авсан НӨАТ-тэй үнийн дүнгээс 0 хувийн хөнгөлөлт эдэлнэ.
- 2.9. Худалдан авагч нь Хавсралт 2-д заасан Карт ашиглах зааврыг карт эзэмших өөрийн ажилтан тус бүрт танилцуулж, түүнийг мөрдүүлж ажиллана.
- 2.10. Картыг зээлээр цэнэглэж байгаа тохиолдолд, түгээлт тус бүрт шатахууны картыг уншуулах бөгөөд карт цэнэглэснээс илүү хэмжээгээр ШТС-аас зээл авах эрхгүй байна.
- 2.11. Худалдан авагч нь бүтээгдэхүүн хүлээн авах шатахууны ерөнхий дансны дугаарыг Хавсралт 1-д тусгана.
- 2.12. Худалдан авагчид хүлээлгэн өгсөн боловч үнэ нь төлөгдөөгүй байгаа бүтээгдэхүүний үнэ төлөгдөх найдваргүй гэж Худалдагч үзвэл уг бүтээгдэхүүнийг захиран зарцуулах эрхийг өөртөө шилжүүлэн авахыг шаардах эрхтэй ба Худалдан авагч үүнд саад хийх эрхгүй.
- 2.13. Хүлээн авсан боловч үнэ нь бүрэн төлөгдөөгүй байгаа бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээний бүрэн бүтэн байдлыг худалдан авагч хариуцах ба аливаа үрэгдэл, дутагдал гарсан явдал нь бүтээгдэхүүний үнэ төлөх үүргээс Худалдан авагчийг чөлөөлөх буюу хөнгөлөх үндэслэл болохгүй.
- 2.14. Худалдагч нь Худалдан авагчид Хавсралт 1-д заасан ерөнхий дансыг энэхүү гэрээний 2.2-т заасан хэмжээнд багтааж худалдан авагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу цэнэглэх бөгөөд худалдан авагчид хүлээлгэн өгсөнөөс хойш эрсдэлийг хариуцахгүй.
- 2.15. Худалдан авагч шатахууны картын нууц дугаар алдагдах эрсдэлийг бүрэн хариуцна.

#### **Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг**

- 3.1. Бүтээгдэхүүний төлбөрийг Худалдагчид энэхүү гэрээний 2.5-д заасны дагуу хугацаа хэтрүүлэлгүй төлөх үүрэгтэй.
- 3.2. Худалдан авагч нь бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээг шалгаж, хүлээн авах үүрэгтэй.
- 3.3. Худалдан авагч бүтээгдэхүүн хүлээн авснаас хойш барааны чанар муудсан ба тоо хэмжээ өөрчлөгдөх, устах зэрэг бүх эрсдэлийг дангаар хариуцна.
- 3.4. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Худалдагчаас шаардах эрхтэй.

#### **Дөрөв. Худалдагчийн эрх, үүрэг**

- 4.1. Худалдагч нь эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй Монгол Улсын чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг Худалдагчийн эзэмшлийн шатахууны картаар дамжуулан нийлүүлэх үүрэгтэй.



- 4.2. Худалдан авагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд энэхүү гэрээний 5.1-т заасны дагуу алдангийн хэмжээг тооцон авах эрхтэй.
- 4.3. Худалдан авагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд худалдан авагчийн барьцаалсан хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэн, захиран зарцуулах эрхтэй
- 4.4. Худалдагч тал нь биет байдлын доголдолтой бүтээгдэхүүн нийлүүлсэн нь хүлээн авах явцад баримтаар илэрсэн тохиолдолд түүнтэй холбоотой бүх зардлыг бие даан хариуцаж доголдлыг арилгана.
- 4.5. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг худалдан авагчаас шаардах эрхтэй.
- 4.6. Худалдан авагчийн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухай шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

#### **Тав. Хариуцлага**

- 5.1. Худалдан авагч нь энэхүү гэрээний 2.5-д заасан хугацаанд худалдан авсан бүтээгдэхүүний төлбөрийг төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-иар тооцож хоног тутам алдангийг төлнө.
- 5.2. Иргэний хуулийн 232.8 дахь хэсгийг үндэслэн, талууд нөхцөл байдлыг үнэлсэний үндсэн дээр гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тал нь хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх алданги төлөхөөр тохиролцож, тэр хэмжээгээр нөгөө тал нь нэхэмжлэх, буруутай тал нь төлж барагдуулахаар хүлээн зөвшөөрч байгаа ба тохиролцсон алданги, тооцсон үнийн дүнгийн хэмжээний талаар аливаа маргаан үүсгэхгүй.
- 5.3. Гэрээний үүргээ гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй буруутай тал тийнхүү гүйцэтгээгүйгээс нөгөө талд учирсан бүх хохирол, зардал (хууль зүйн туслалцаа авсны төлбөр, нотариатын зардал, улсын тэмдэгтийн хураамж г.м)-ыг төлж барагдуулах үүрэгтэй.

#### **Зургаа. Давагдашгүй хүчин зүйл**

- 6.1. Талууд давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн нөхцлийн үр дүнд (гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн улмаас) хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгээгүй хариуцлагаас бүрэн чөлөөлөгдөнө. Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл гэж онцгой нөхцөл байдлаар үүссэн нөхцөл буюу тэдгээрийг талууд урьдчилан мэдэж таслан зогсоох боломжгүй (түймэр, үер, газар хөдлөлт буюу байгалийн бусад үзэгдэл болон дайн, бүслэлт, Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон арга хэмжээ, хорио цээр, бүх төрлийн хязгаарлалт, удаашрал, мөн үйлдвэрлэгч компаниас шалтгаалсан тасалдал, хомсдол г.м) ба эдгээр нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулж байгаа нөхцөл байдалд тооцогдоно.
- 6.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тал нь нөгөө талдаа 3 хоногийн дотор мэдэгдэнэ. Мэдэгдэл нь факсаар, эрх бүхий ажилтны имэйлээр, шуудангаар илгээгдэж болох ба цаашид эх хувиараа хүргэгдэнэ. Мэдэгдсэн огноог шуудан, харилцааны огноогоор тооцно.
- 6.3. Талууд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлөөс болоод үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдалтай тулгарсан тухайгаа энэхүү зүйлд заасан аргаар мэдэгдээгүй



бол гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлд үндэслэн хариуцлагаас чөлөөлөгдөх эрхээ алдана.

- 6.4. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас олгосон давагдашгүй хүчин зүйлийн баталгаа нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл бий болсоны хангалттай нотолгоо болно.

#### **Долоо. Гэрээ цуцлах, дуусгавар болгох**

- 7.1 Гэрээний хугацаа дууссан, эсхүл аль нэг тал Гэрээг дуусгавар болгох тухай саналаа 1 /нэг/ сарын өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдсэний үндсэн дээр харилцан тохиролцсон бол гэрээг дуусгавар болгож болно.
- 7.2 Дор дурдсан нөхцөлд гэрээг цуцалж болно:
- 7.2.1. Талуудын аль нэг тал гэрээнд заасан үүргээ 2-оос дээш удаа зөрчсөн бол;
- 7.2.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл үүссэний улмаас Худалдан авагч нь 60 (жар)-аас дээш хоногийн хугацаанд Гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон;
- 7.2.3. Худалдан авагч төлбөрийн чадваргүй болсон нь илт болсон.
- 7.3. Гэрээний 7.2-г зааснаар Гэрээг цуцалсан бол тийнхүү гэрээг цуцлах өдрөөс өмнө Худалдагчийн нийлүүлсэн бүтээгдэхүүний үнийг Худалдан авагч төлөх үүрэгтэй.

#### **Найм. Бусад**

- 8.1. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт, хавсралт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талууд гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр болох ба энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 8.2. Энэхүү гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба тохиролцоонд хүрэхгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.3. Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа харилцан нэг нэгнийхээ эрхийг хүндэтгэж, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд өөрөөс шалтгаалах бүхий л зохистой арга хэмжээг авна.
- 8.4 Энэхүү гэрээ болон түүний хавсралтуудыг талууд нууцлан хадгалж хамгаалах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.
- 8.5. Энэхүү гэрээг 3 эх хувь үйлдсэн бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй байна.
- 8.6. Энэхүү гэрээнд талууд 2023 оны –р сарын –ны өдөр гарын үсэг зурж, баталгаажуулав.

#### **Талуудын хууль ёсны хаяг:**

##### **Худалдагч:**

Говьсүмбэр аймаг Сүмбэр сум  
1-р баг “НИК ХХК-ийн Говьсүмбэр  
Нефть Хангамжийн салбар”

##### **Худалдан авагч:**

Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум 3-р баг  
Аймгийн ЗДТГ азар-ын байранд



Утас: 99014302, 88027123, 89022108  
Факс: 330808

Утас: 99079355, 99053009

Данс:

ХААН банк: - ГСА-5990057622 /₮/

И-мэйл хаяг:

**Гэрээ байгуулсан:**

ЭНЭ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ НЭГ БҮРЧЛЭН УНШИЖ, ТАНИЛЦАН  
БАТАЛГААЖУУЛСАН:

**Худалдагчийг төлөөлж:**

Говьсүмбэр НХС-ын ахлах нягтлан бодогч

..... [гарын үсэг]

Г.Ганбаяр

**Худалдан авагчийг төлөөлж:**

нягтлан бодогч:

..... [гарын үсэг]

Н.Одонтуяа

Төвийн ШТС-4 эрхлэгч

..... [гарын үсэг]

Н.Янжиндулам



Газрын тосны бүтээгдэхүүн зээлээр  
нийлүүлэх ..... оны ..... сарын .....-ны өдрийн .....  
тоот гэрээний Хавсралт №1

| Шатахууныг зээлийн картаар худалдан авах , картын ерөнхий дансны мэдээлэл |                  |                       |  |  |
|---|------------------|-----------------------|--|--|
| №   | Байгууллагын нэр | Ерөнхий дансны дугаар | Тухайн зээл<br>хүссэн сард<br>цэнэглэх<br>хэмжээ | Нэг удаагийн<br>худалдан авалтын<br>хэмжээ |
| 1   | “.....” ХХК      | 93600000.....         | ...0 000 000<br>төгрөг                           |  |

**Худалдагчийг төлөөлж:**

Говьсүмбэр НХС-ын ахлах нягтлан бодогч

..... [гарын үсэг]

Г.Ганбаяр

Төвийн ШТС-4 эрхлэгч

..... [гарын үсэг]

Н.Янжиндулам

**Худалдан авагчийг төлөөлж:**

нягтлан бодогч:

..... [гарын үсэг]

Н.Одонтуяа

Худалдагч /гарын үсэг/

Худалдан авагч /гарын үсэг/

### Албаны орон сууц хөлслөх гэрээ

2024 оны 01 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 01

Говьсүмбэр

Албаны орон сууц хөлслөх гэрээг / цаашид гэрээ гэх/ Өмчлөгч Орон нутгийн өмчийн газрыг төлөөлж / цаашид ОНӨГ гэх/ Орон нутгийн өмчийн газрын дарга ажилтай **Алтангэрэл овогтой Отгонтуяа** Өмч эзэмшигчийг төлөөлж /цаашид орон сууц хөлслүүлэгч гэх/ **БШУГ-ын дарга ажилтай Амгаа овогтой Зургаанжин**. Хөлслөгчийг төлөөлж /цаашид Орон сууц хөлслөгч гэх/ Ерөнхий боловсролын 2-р сургуулийн Физикийн багш **Чулуунбаатар овогтой Уламбаяр /рд: ЛЙ84090270/** нар нь Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Монгол Улсын бусад хууль тогтоомжийг үндэслэн, харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээгээр Өмч эзэмшигч нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3 дугаар багт байрлах 2 орцны 6-р байрны 40 тоот 45м<sup>2</sup> талбай бүхий сууцны зориулалттай орон сууцны 2 өрөөг хөлслөгчийн эзэмшилд шилжүүлэх, хөлслөгч нь хэлэлцэн тохирсон төлбөрийг төлөх үүргийг хүлээхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Орон сууцны хөлсийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаас тогтоосон 1 м<sup>2</sup> талбайн жишиг үнээр бодож тооцно.
- 1.3. Уг орон сууц нь бусдын өр төлбөрт битүүмжлэгдээгүй, аль нэг байгууллага, иргэний өмчлөлд шилжээгүй, барьцаалагдаагүй, түрээслэгдээгүй болно.
- 1.4. Хөлслүүлсэн орон сууцны сарын төлбөр **54000 /тавин дөрвөн мянган/** төгрөг /тоогоор, үсгээр/
- 1.5. Хөлслөгч нь орон сууцны хөлсийг сар бүр төлөх бөгөөд Төрийн сангын **100 220 000 953** тоот дансанд сар бүрийн 20-ны өдрийн дотор, ашиглалт / цахилгаан, дулаан, интернэт, цэвэр, бохир ус, СӨХ/ -ын зардлыг холбогдох газарт төлж барагдуулна.

#### Хоёр. Орон нутгийн өмчийн газрын эрх, үүрэг

- 2.1. Хөлсөлж буй орон сууцыг бүртгэлийн дагуу өмч эзэмшүүлэх гэрээнд бүрэн тусгаж, орон сууцыг хүлээлцүүлэхэд хяналт тавина.
- 2.2. Хөлслүүлсэн орон сууцанд хөрөнгө оруулалт хийхээр бол холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх буюу хөлслүүлэгч болон хөлслөгчийн гэрээний үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.
- 2.3. Хөлслүүлэгч, хөлслөгч талуудын аль нэг нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд гэрээг дангаарад цуцлах эрхтэй.

#### Гурав. Хөлслүүлэгчийн эрх, үүрэг

- 3.1. Хөлслүүлэгч нь ашиглалтын шаардлага хангасан, биет байдлын болон эрхийн доголдолгүй орон сууцыг хөлслөгчийн эзэмшилд акт үйлдэж гарын үсэг зурж, хүлээлгэн өгнө.
- 3.2. Хөлслүүлэгч хөлслөгчөөс орон сууцны талбайн хөлс болон энэхүү гэрээнд заасан цахилгаан, дулаан, интернэт, цэвэр, бохир ус, СӨХ-ны зардлыг төлөхийг шаардах эрхтэй.
- 3.3. Орон сууц хөлслөгч нь төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн, Хөдөлмөрийн тухай хуулийн 39, 40 дүгээр зүйлд заасны дагуу хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан, мөн хуулийн 37 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон гэрээнд заасан төлбөрийг хөлслөгч гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй болон бусад зайлшгүй нөхцөл байдлын улмаас хугацаанаас нь өмнө гэрээг цуцлахаар бол хөлслүүлэгч нь орон сууц хөлслөгчид нэг сарын өмнө мэдэгдэнэ.
- 3.4. Хөлслөгч нь урьдчилан сануулсаар байхад өөрийн эзэмшилдээ байгаа орон сууцны ашиглалтыг муутгасан, гэмтээсэн, эсхүл муутгах, гэмтээх бодит нөхцөл байдал үүсгэсэн, орон сууцны өрөө тасалгааг өргөтгөсөн, ханыг буулгах зэргээр орон сууцны инженерийн байгууламжийн аюулгүй байдлыг зөрчиж, дур мэдэн өөрчилсөн, эзэмшилдээ байгаа хөрөнгийг

бусдад давхар хөлслүүлэх, бусдыг байрлуулах зэргээр гэрээнд заасан нөхцлийг илтэд зөрчсөн тохиолдолд орон сууц хөлслөх гэрээг хугацаанаас өмнө цуцлаж, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.

3.5 Орон сууц хөлслөх гэрээг цуцлахад иргэний хуулийн 294.2, 294.3-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

3.6.Орон сууц хөлслөх гэрээг цуцлах тохиолдол хөлслөгч талд энэ талаар бичгээр мэдэгдэнэ.

#### Дөрөв. Хөлслөгчийн эрх, үүрэг

4.1. Хөлслөгч нь гэрээнд заасан хөрөнгийг захиран зарцуулахгүй бөгөөд орон сууцыг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглан урсгал засварыг хариуцаж, түүний бүрэн бүтэн байдлыг хангана.

4.2. Хөлслөгч тал гэрээнд заасан хугацаанд орон сууцны хөлс, орон сууц ашигласан /цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, холбоо, интернэт, СӨХ/ зардлыг холбогдох газарт бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

4.3 Өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр орон сууцны хийц, зохион байгуулалтыг өөрчлөх буюу засварлахгүй байх, гэрээний хугацаа дуусч цаашид хөлслөхгүй тохиолдолд орон сууцыг хөлслүүлэгчид бүрэн бүтэн биет байдлын доголдолгүйгээр буцаан хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ.

4.4. Хөлслөгч энэхүү гэрээний 2.5-д заасны дагуу тухайн орон сууцыг буруу эзэмшиж ашигласнаас үүссэн засвар, эвдрэл, гэмтлийг засварын хохирлын нөхөн төлбөрийг бүрэн хариуцна.

4.5. Хөлслөгч нь орон сууц хөлслөх гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол гэрээний хугацаа дуусахаас хоёр сарын өмнө тухайн орон сууцыг үргэлжлүүлэн хөлслөх гэрээг сунгах тухай хүсэлтээ хөлслүүлэгчид бичгээр гаргаж болох бөгөөд Иргэний хуулийн 294.2-т заасан үндэслэл байхгүй бол хөлслүүлэгч гэрээг сунгаж болно.

4.6 Орон сууц даатгуулах асуудлыг хөлслөгч тал хариуцна.

4.7 Хөлслөгч нь хөлслүүлсэн орон сууцыг барьцаалах, түүгээр баталгаа гаргах, орон сууцыг бүхэлд нь буюу түүний хэсгийг гуравдагч этгээдэд дамжуулан хөлслөхийг хориглоно.

4.8. Хөлслөгч нь ашиглалтын шаардлага хангасан, биет байдлын болон эрхийн доголдолгүй орон сууцыг актын дагуу хүлээн авна.

4.9. Гэрээний хугацаа дууссанаар хөлслүүлсэн орон сууцыг түүнээс салгаж үл болох хөрөнгө оруулалт, засварын хамт хөлслүүлэгчид актын дагуу хүлээлгэн өгнө.

#### Тав. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа

5.1. Энэхүү гэрээ нь 2024 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 21-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

5.2. Гэрээг 3 хувь үйлдэж, 3 тал гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр байна.

#### Зургаа. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах

6.1. Хөлслөгч гэрээгээр тохиролцсон төлбөр, тооцоог 2 сар хүртэлх хугацаагаар хожимдуулах, хууль болон гэрээнд тусгасан үүргээ биелүүлээгүй,

6.2.Орон нутгийн эрх бүхий байгууллагаас тухайн албаны орон сууцыг өөр байгууллагад шилжүүлэх, хувьчлах шийдвэр гарсан,

6.3. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хөлслүүлэгч эрх бүхий байгууллагуудын саналыг авч хөлслөгчид гаргасан зөрчлийг арилгах хугацаа олгож болно,


6.4 Аль нэг тал гэрээг цуцлах шийдвэр гарсан тохиолдолд 30 хоногийн өмнө талуудад мэдэгдэнэ.

#### ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

Орон нутгийн өмчийн газрыг төлөөлж:  
.....Алтангэрэл.....  
.....Отгонтуяа.....  
/Овог нэр/  
.....  
/Гарын үсэг/ 424  
УТ 1104 4614909

Хөлслүүлэгчийг төлөөлж:  
БШУГ-ын Дарга  
.....Амгаа.....  
.....Зургаанжин.....  
/Овог нэр/  
.....  
/гарын үсэг/

Хөлслөгчийг төлөөлж:  
Багш  
....Чулуунбаатар...  
....Уламбаяр.....  
/Овог нэр/  
.....  
/гарын үсэг/




БАТЛАВ:  
 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН  
 ГАЗРЫН ДАРГА *Тогтоо* А.ЗУРГААНЖИН

9020314 4216131555

БАТЛАВ:

ЗЭНДМЭНЭ БУЯН АРВИЖИХ ЭРДЭНЭ  
 ХХК-НИЙ ЗАХИРАЛ *Улс* Ч.НАРАНТУЯА



**БАРАА МАТЕРИАЛ**

**БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2021 онь *01* дугаар сар *04*

№

Говьсүмбэр аймаг

Нэг талаас 4615867 регистрийн дугаар бүхий *Зэндмэнэ буян арвижих эрдэнэ ХХК* /цаашид нийлүүлэгч гэх/-ыг төлөөлж *захирал* албан тушаалтай *Чулуунбаатар овогтой Нарантуяа*, Нөгөө талаас 9020314 регистрийн дугаар бүхий *Говьсүмбэр аймгийн Боловсрол Соёл Урлагын газар* /цаашид Худалдан авагч гэх/ төлөөлж Нягтлан бодогч албан тушаалтай *Номинзул овогтой Одонтуяа* нар харилцан тохиролцов.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Гэрээний нөхцлийн дагуу худалдагч нь стандарт шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн, техник тоног төхөөрөмж болон түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, төлбөрийг хийнэ.
- 1.2 Шаардлагатай бусад тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүнийг захиалгын дагуу бэлтгэн нийлүүлэх үйлчилгээг үзүүлж, төлбөрийг хүлээн авна.
- 1.3 Гэрээний үнэ болон төлбөр хийх хугацааг харилцан тохиролцож болно.

**ХОЁР: НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ**

- 2.1 Худалдан авагчийн захиалгыг хүлээн авч захиалгын дагуу бараа бүтээгдэхүүнийг заасан хугацаанд нийлүүлнэ.
- 2.2 Хэрэглээний стандарт шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг өргөн нэр төрлөөр худалдаална.

2.3 Борлуулалтын баримт бичиг хөтлөх

2.4 Бараа бүтээгдэхүүнийг зарлагын баримт, нэхэмжлэхийн хамтаар худалдан авагчид шилжүүлнэ.

2.5 Төлбөрийг гэрээнд заасан хэмжээгээр хүлээн авах

2.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг худалдан авагчаас шаардах.

2.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### ГУРАВ: ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Нийлүүлэгчээс чанар болон эрхийн доголдолгүй бараа бүтээгдэхүүн худалдаалах шаардах.

3.2 Шаардлагатай бараа бүтээгдэхүүний захиалгыг урьдчилан өгөх эсвэл шууд худалдан авах.

3.3 Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүнийг шалгаж хүлээн авах ба ашиглах явцад илэрсэн доголдолыг нийлүүлэгч талд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх.

3.4 Хөрөнгийг хүлээн авахдаа тоо, чанар, иж бүрдэлийг шалгаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлнэ.

3.5 Нийлүүлэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн болон биелүүлээгүйгээс өөрт учирсан хохирлыг шаардах, нэхэмжлэх

3.6 Худалдан авсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг нийлүүлэгч талд тохирсон хугацаандаа төлөх үүрэгтэй.

3.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### ДӨРӨВ: ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

4.1 Худалдан авагч тал хөрөнгийн төлбөрийг нийлүүлэгч талын нэхэмжлэлд үндэслэн бэлэн бусаар шилжүүлнэ.

4.2 Худалдан авагч тал бараа бүтээгдэхүүний төлбөрийг шилжүүлсэн тухай нийлүүлэгч тал ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

#### ТАВ: ХӨРӨНГӨ ШИЛЖИХ

5.1 Худалдсан хөрөнгийг худалдан авагчид шилжүүлснээр хөрөнгө устаж, гэмтэсний эрсдэл худалдан авагчид шилжинэ.

5.2 Худалдан авагч хөрөнгийг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн бол түүнийг хөрөнгө хүлээн авсанд тооцно.

#### ЗУРГАА: ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд итгэл эвдэхгүй байх зарчмыг мөрдлөгө болгоно.
- 6.2 Нийлүүлэгчийн буруугаас хөрөнгийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд хоног дутам шилжүүлээгүй хөрөнгийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож худалдан авагчид торгууль төлнө.
- 6.3 Худалдан авагч нь бараа материалын төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш өөрийн буруугаас шилжүүлээгүй тохиолдолд хоног дутам биелүүлээгүй гэрээний үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар тооцож нийлүүлэгчид торгууль төлнө.
- 6.4 Худалдсан хөрөнгийн үнэ тухайн үеийн ижил, чанар, төрлийн хөрөнгийн зах зээлийн үнээс илт зөрүүтэй бол талууд хөрөнгийн үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.
- 6.5 Энэ гэрээний нөхцлийг зөрчснөөс аль нэг талууд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, барагдуулна.
- 6.6 Тохиролцсон үнийг нэг талын санаачлагаар өөрчлөхгүй байх.

#### ДОЛОО: ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Давагдашгүй хүчин зүйл /үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хугацаагаар хойшлуулах болно.
- 7.2 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.
- 7.3 Тухайн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийн хугацаа 7 болон түүнээс дээш хоногоор хойшлогдвол талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирол төлүүлэхийг шаардахгүй.

#### НАЙМ: МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.
- 8.2 Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын Хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ЕС: ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨХ БОЛОХ, ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

- 9.1 Энэхүү гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгч нарт гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдөр хүчин төгөлдөр болсонд тооцно.
- 9.2 Гэрээний үйлчлэх хугацаа 2021 оны 01 сарын 04 өдрөөс 2024 оны 12 сарын 31 өдөр хүртэл байна.
- 9.3 Гэрээний хугацааг 2 тал бичгээр тохиролцсноор сунгаж болно.

9.4 Дараахь тохиолдолд гэрээ дуусгавар болсон нь талуудын нэг нэгнийхээ өмнө биелүүлээгүй байсан болон байгаа үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.4.1 Талууд зөвшилцснөөр

9.4.2 Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр

9.4.3 Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр

АРАВ: БУСАД ЗҮЙЛ

10.1 Гэрээг 2% үйлдэж, тал тус бүр нэг нэг хувийг хадгална.

10.2 Талууд энэхүү гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа харилцан тохиролцож, бичгээр нэмэлт өөрчлөлт оруулна.


10.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

10.4 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдлөгө болноно.

Гэрээ байгуулсан:

Худалдан авагч тал:

Говьсүмбэр аймгийн Боловсрол Соёл Урлагын


газрын Нягтлан бодогч  Н.Одонтүяа

Утас: 70543160



Нийлүүлэгч тал:

Зэндмэнэ буян арвижих эрдэнэ

ХХК-ны захирал  Нарантуяа

Утас: 99049552

